



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.4, 47 дугаар зүйлийн 47.1, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.17 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 29 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ногдол ашгийн бодлого"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 43.44 төгрөгийн ногдол ашгийг 2026 оны 04 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг хуваарилж дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор ногдол ашиг хуваарилалтын тайланг гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР